

## 1990-ЭЭД ОНООС ХОЙШИХ ЗАРИМ ӨГҮҮЛЛЭГТ БОЛЗОЛТ ДҮРСЛЭЛИЙГ АШИГЛАСАН БАЙДАЛ

Б.Хуритүяа

### Нэг: Болзолт дүрслэл гэж юу вэ?

Уран сайхны болзолт дүрслэл гэдэг нь олон салаа, олон утгатай ойлголт юм. Ерөнхийд нь уран сайхны дүрслэлийн зарчим гэж ойлгож болно. Орчин үеийн гоозүйд болзолт дүрслэлийг анхдагч ба хоёрдогч гэж ялган үздэг. Энэ нь дүрийн үнэмшилтэй байдлын хэмжээ, түүнийг ухамсарлах байдлаас шалтгаалдаг.

Анхдагч болзолт дүрслэл нь уран сайхны хувьд үнэмшилтэй, зохиомол байдал нь ялгардаггүй, зохиогч нь өөрөө болзолт чанарыг тодотгодоггүй. Ийм дүрслэл нь байх ёстой юм шиг санагддаг.

Хоёрдогч болзолт чанарыг орчин үеийн уран зохиолд хэрэглэдэг. Уран зохиолын хэлбэрт уран сайхны үнэмшилтэй байдлыг албаар эвддэг.

Миф, үлгэр домгийн дүрүүдийн анхдагч нь хоёрдогчдоо шилжиж ордог. Жишээ нь: Гёте "Фауст", Булгаков "Мастер, Маргарита хоёр".

Болзолт дүр нь уран сэтгэмж /фантастик/, хачин жаягт урлаг /гротеск/, хэтрүүлэг /гипербола/, бэлгэ тэмдэг /символ/, ёгтлол.... зэрэг хэлбэртэй. Өөрөөр хэлбэл, болзолт дүрийг ёгт үлгэр, уран зохиолын үлгэр, шинжлэх ухааны уран зөгнөлт зохиол зэргээс харж болно.

Тэгвэл бодит байдлын хэлбэрийг эвдэх чиглэлтэй энэ аргыг манай уран зохиолд 1990 оноос өмнөх үед ашиглах нь ховор байж. Тэр үеийн социалист реализмын уран зохиолд хэлэх гэсэн санаагаа болзолт дүрслэл буюу бодит амьдрал дээр байж болшгүй дүрслэлээр илэрхийлэх боломжгүй, бодит байдлыг бодит дүрслэлээр л илэрхийлэх ёстой гэж үздэг байснаас тэр. Харин 90-ээд оноос нийгэм нээлттэй болсноор энэ аргыг чөлөөтэй ашиглах болжээ.

Энэхүү арга манай уран зохиолд хэрхэн, яаж хөгжиж буйг илрүүлэхийн үүднээс гурван өгүүллэгийг жишээлэн авлаа.

### Хоёр: Үндсэн хэсэг

#### Урлагийн сэдэвт өгүүллэг

Б. Дариймаагийн "Лууны нүд" өгүүллэгт бодит байдал хийгээд урлагийн хоорондын харьцааг гаргасан. Өгүүллэгт зураач Маргад тогос шувууны хүсэлтээр лууг зуран өгч, тэрхүү луугаа нүдээр нь амилуулахын тулд луу гэж ямар

амьтан байдгийг харах гэж хайн явна. Тогос шувуу бол олон түмнийг төлөөлсөн дүр юм. Шувууны зүгээс лууг нүдээр нь амилуулахыг хүсэж байгаагаар хүмүүсийн урлагт тавих шаардлага, урлагийн мэдрэмж улам нарийсч байгааг, мөн зураас тогос шувууны хүссэнээр лууны нүдийг нь амилуулах гэж эрэл хайгуул хийж, эцэст нь зорьсондоо хүрч байгаагаар урлагийг ойлгогчдын шаардлага хэдий өндөр байна, уран бүтээлч хүн тэр хэмжээгээр ур чадварын хувьд өсөж байдаг гэсэн санааг илэрхийлсэн.

/Луу амилахад алтан гүмада цэцэг цоморлигоо дэлгэж, тогос шувууны заяа дэлгэрдэг/ гэсэн дүрслэлээр хүмүүс жинхэнэ урлагийг ойлгож мэдэрснээр сэтгэлийн цэнгэл эдэлж, эрх чөлөөг мэдэрдэг гэсэн санаагаар ойлгож болно.

### 2. Модернист чиглэлийн өгүүллэг

Г. Аюурзанын "Уулын монолог" өгүүллэгт хүн нийгмийн харьцааны эсрэг тэсрэг байдал хийгээд зөрчлийг тусгасан. Өдрөөс өдөрт тасралтгүй хөгжиж буй нийгэмтэйгээ хүн хөл нийлүүлэн алхахын тулд өөрийн төрөлх чанараараа байж байддаггүй, байнга дотоод сэтгэлийнхээ эсрэг зогсож, хүсээгүй зүйлээ хийж, хүсээгүй зүйлээ ярьдаг. Тэгвэл уг өгүүллэгийн баатар Гүнболд хүний мөн чанарыг үгүй болгогч нийгмээсээ дайжиж, ойд чононуудын дунд өөрийн хүслээр чөлөөтэй амьдарч байна. Түүний амьдарч байсан хүний нийгэмд юу зөв, юу бурууг мэдэхгүй бол амьдрах аргагүй. Өөрөө хүсч буй ч тэр нь болохгүй зүйл бол орхихоос аргагүй, харин өөрөө хүсэхгүй байгаа ч тэр нь болох бол хийхээс аргагүй болно.

Ингэж дотор сэтгэлийнхээ эсрэг албадмал хуурмаг амьдралыг жигшсэнээс нийслэлийн нэгэн байшингийн ханан дээр "анархийн тэмдэг" тавьж байна. Гэтэл хүнгүй ой шугуйд ирээд амьдарч байгаа агуйнхаа ханан дээр "Нийслэл" гэж бичихийг хүсэж байна. Ой шугуйг сэтгэл зүрхнийхээ нийслэл гэж нэрлэсний учир нь, энд хүний нийгмийн хууль үйлчлэхгүй, хуурмаг дүр эсгэхгүйгээр хүссэнээрээ амьдрах эрх чөлөөг мэдэрснээс тэр. Хүн гэдэг амьтан хэт нийгэмшсэнээс төрөлх мөн чанараа алдаж байгааг илэрхийлэхийн тулд уг дүрийг сонгосон.

### 3. Улс төрийн сэдэвт өгүүллэг.

Ж. Барамсайн “Биегүй сүүдэр” өгүүллэгт 1930-аад оны үед дотоод явдлын яамны ногоон малгайтнууд гэмгүй олныг хэлмэгдүүлэн зовоож байсныг, гэм буруугүй эгэл жирийн гэмгүй олон хүмүүс хэрхэн хэлмэгдэн зовж хорвоог орхисныг, түүхэн тэр цагт болсон явдлын үнэн зөвийг шүүн тогтоосныг “сүүдэр, амьгүй бие”-ийн тусламжтайгаар гаргахыг зорьжээ.

Бурханы шашинд бие махбод, оюун ухаан хоёр нэг дор оршнооор хүн гэдэг нэрийг авч амьдардаг бөгөөд харин бие махбодь үхмэгц сүнс нь биеэс салж, өөр махбодод шингэн ордог гэж үздэг. Амьд ахуй цагтаа буруу зүйл хийлгүй зөвөөр явсан бол сүнс дахин хүний биед шингэх бөгөөд харин бусдыг зовоон шаналгаж явсан хүний сүнс адгуусан төрөлт амьтанд шингэн ордог гэсэн ойлголтыг уг өгүүллэгт шингээн өгчээ.

Амьд ахуйдаа гэмгүй олныг байцаан тарчлааж, тэдний зовлонг бахтайгаар өөрийн жаргал болгож, тэднээс булаасан хөрөнгөөр сайхан амьдарсан ч эцэстээ бие нь газар хэвтэж, сүнс нь тархиндаа буудуулах тавилантай тарвага болж байдаг. Нөгөө талд, хорин долоохон насандаа гэм зэмгүй байтлаа хилс хэрэгт гүтгэгдэн хороогдсон хүний сүнс нь нэгэн ламын биед хувилсан байна.

Өгүүллэгт тухайн цаг үед болсон хэрэг явдлыг үнэн зөвөөр дэлгэн тавихын тулд хүний биеийн нэгээхэн хэсэг гэж болох “сүүдэр”-ийг сонгон авчээ. Өөрөөр хэлбэл, сүүдэр нь хүний нэг хэсэг, мөнхийн дагуул учраас тэдний хийсэн сайн, муу үйлийг ялган дэнслэгч болсноор дүрслэгдсэн.

### Дүгнэлт:

Зөвхөн урлаг ч биш, ерөөсөө хүний амьдралд ямарваа зүйлийг хийж бүтээхийн тулд тодорхой хэмжээгээр хөлс хөдөлмөр зарцуулдаг гэсэн санааг илэрхийлэхийн тулд луу /үлгэрийн дүр/, хүн амьтан хоёрын харьцаа /тогос шувуу хүний хэлээр зураачтай ярьж байгаа/, зураг амилах /луу зурагнаас амилан гарч байгаа/ зэрэг.

Хүн нийгмийн зөрчлийг гаргахын тулд хүн нь нийгмээсээ дайжин, чононуудын дунд амьдарч, өөрийгөө хүн биш гэж тооцож байгаа, нийслэлийнхээ нэгэн байшингийн ханан дээр “анархийн тэмдэг” тавихыг хүссэн байтлаа ой дахь агуйн ханан дээр сэтгэл зүрхний “Нийслэл” гэж бичихийг хүсэж байгаа зэрэг түүхэн тодорхой цаг үед болсон бодит явдлыг өгүүлэхдээ “сүүдэр, амьгүй бие” хоёрын харьцааг үзүүлсэн зэрэг бодит амьдралд байж болшгүй дүрслэл болох болзолт дүрслэлээр дамжуулан үзүүлжээ.

### Номзүй:

1. “Монгол өгүүллэгийн цоморлиг”, УБ., 2006
2. “Литературный энциклопедический словарь”, Москва., 1987
3. Байгальсайхан. С, “Уран дүрийн онолын лекцүүд” УБ., 2005
4. Галбаатар. Д “Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд” УБ., 2001

